



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1338  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН  
Я.СОДНОМДАРЖАА ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Ядамсүрэнгийн Содномдаржаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Ядамсүрэнгийн Содномдаржаагийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр


ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Ядамсүрэнгийн Содномдаржаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИТХ-ИЙН 2020 ОНЫ СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Я.СОДНОМДАРЖААГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 оны 7-р сарын 16-ны өдөр

Улсын нийслэл Улаанбаатар хот эрүүл, аюулгүй тайван орчин бүхий, эдийн засаг нийгэм соёлын төв байх үүднээс 4 ЭРҮҮЛ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр энэ удаагийн НИТХ-ын сонгуульд бие даан нэр дэвшихээр мөрийн хөтөлбөр боловсрууллаа.

**Нэг. Эрүүл орчинтой нийслэл**


- 1.1. Нийслэлийн агаарын бохирдол, орчны эрүүл ахуйн иж бүрэн үнэлгээ, мониторингийн судалгаа хийнэ.
- 1.2. Нийслэлийн агаарын бохирдлын эх үүсвэрийн бууруулах ажлыг үе шаттай эхлүүлнэ.
- 1.3. Нүхэн жорлонгүй нийслэл хөтөлбөр хэрэгжүүлж, иргэдийн сэтгэлгээнд өөрчлөлт хийх замаар жорлонгоо өөрчлөх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4. Хөрсний бохирдлыг бууруулахын тулд хөршийн холбоог сэргээх замаар гудамж бүрээр асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр боловсруулна.
- 1.5. Тоосжилтыг бууруулахын тулд “Нэг айл 10 мод” хөтөлбөр хэрэгжүүлж, нийслэлийн гэр хорооллын гудамж, хашааг “ногоон гудамж” болгох аяныг эхлүүлнэ.
- 1.6. Үерийн уснаас сэргийлэхийн тулд цогц төлөвлөлт хийж, эхний ээлжинд үерийн усны урсацын голдиролыг тогтоон, тооцож, сувагчлалыг шинээр барьж байгуулах ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 1.7. Үерийн усны эхэнд болон урсац голдирол дагуу буусан айл өрхүүдэд шинээр газар олгох замаар нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 1.8. Явган зам барих ажлыг гэр хороололд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.9. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, кластерийн тогтолцоогоор хөгжүүлэх эдийн засгийн хөшүүргийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.10. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор хийн түлшээр ажилладаг авто машиныг дэмжих татварын болон санхүүгийн дэмжлэгийн тогтолцоог бий болгох санаачилга гаргаж, хэрэгжүүлнэ.

**Хоёр. Эрүүл төлөвлөлттэй нийслэл**

- 2.1. Хот төлөвлөлтийн цөм нь машин бус ХҮН байхад чиглүүлэх замаар дахин төлөвлөлтийг хэсэгчлэн, үе шаттай зохион байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 2.2. “Эко нийслэл” үзэл баримтлал бүхий бодлого боловсруулан санал болгоно.
- 2.3. Нийслэлийн дагуул дүүрэг, хотуудыг байгуулах, хөгжүүлэх бодлогыг дэмжин ажиллана.
- 2.4. “Ухаалаг нийслэл” байх тогтолцоог санал болгоно.
- 2.5. “Зогсоолын менежмент” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар түгжрэлийг бууруулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.6. Гэр хорооллыг устгах бус хөгжүүлэх бодлого боловсруулж гэр хорооллыг хотын ногоон бүс болох эхлэл тавина.
- 2.7. Дэд бүтцийн хүртээмжийг гэр хороолол руу түлхүү чиглүүлнэ.
- 2.8. Хот төлөвлөлтийн бодлогыг өөрчлөн барилга хоорондын зайг нэмэгдүүлэх замаар орон сууцны ногоон байгууламжийг хамгаалах, нэмэгдүүлэх, хэт төвлөрлийг саармагжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

**Гурав. Эрүүл бизнесийн орчинтой нийслэл**

- 3.1. Нийслэлд бизнес эрхлэх хамгийн таатай орчинг бүрдүүлэх бодлогыг тууштай дэмжиж ажиллана.



- 3.2. Нийслэл дэх үйлчилгээ, нийтийн хоолны газруудын ажиллах цагт тогтоосон хязгаарыг цуцлуулж, зах зээлийн зарчмаараа ажиллах боломжийг олгоно.
- 3.3. Дэлгүүр, худалдаа, үйлчилгээний бизнест нийслэлээс золгох зөвшөөрөлд өөрчлөлт оруулж, бизнесийг дэмжиж зөвшөөрөл олгосон бол орчныг нь хамгаалдаг тогтолцоо руу шилжүүлнэ.
- 3.4. Нийслэлд ЖДҮ үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох асуудлаар Засгийн болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 3.5. Нийслэлийг түшиглэсэн эдийн засгийн болон санхүүгийн чөлөөт бүсийг бий болгох санал, санаачилгыг дэмжиж ажиллана.
- 3.6. Стандарт хангасан бүх бизнесийг дэмждэг тогтолцоог бий болгоно.
- 3.7. Нийслэлд бизнес инкубатор, старт-апп-уудыг дэмжих төвүүдийг Олон улсын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран байгуулна.
- 3.8. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтыг гаргаж, концессын BOT, BOO нөхцлөөр хэрэгжүүлэх төслүүдийг бүх талаар дэмжих ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.

#### **Дөрөв. Эрүүл засаглалтай нийслэл**

- 4.1. Иргэдээ сонсох, иргэний санал санаачилга, өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хариу өгөх тогтолцоог боловсронгуй болгож, ухаалаг шийдэл нэвтрүүлнэ.
- 4.2. Иргэдийн сайн дурын оролцоог хангах ажлыг журамлан шийдвэрлэнэ.
- 4.3. Иргэний хяналтын тогтолцоог бий болгох замаар гэмт, хэрэг зөрчил, хууль бүс үйлдлийг бууруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.4. Дөрөв дэх засаглал болох сэтгүүл зүйн үүргийг нэмэгдүүлэх замаар нийслэлийн төр захиргааны байгууллагад хяналтыг бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 4.5. ИТХ-ын төлөөлөгчдийг намын бус “Иргэний төлөөлөл” байх бодит ажлыг эхлүүлнэ.
- 4.6. Нийтийн эрх ашгийн үүднээс Нийслэлээс гаргах аливаа шийдвэрт иргэдийн саналыг тусгах, санал авах тогтолцоог боловсронгуй болгоно.
- 4.7. Цахим, ухаалаг засаглалыг хөгжүүлэх замаар төрийн үйлчилгээг илүү хялбар, уян хатан болгох алхамыг эхлүүлнэ.
- 4.8. Нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдлагууд, төрийн ажилтнуудын ёс зүй, мэргэжлийн хариуцлагын тогтолцоог сайжруулна.

